



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/100

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.2, 6 дугаар хавсралтын 42 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/58 дугаар захирамжийн хавсралтын 13 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс болон орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажлын ТЭЗҮ, зураг төслийг бэлэн болгох зорилгоор Булган сумын төвд нийтийн эзэмшлийн 2000 м² авто зогсоолын талбай байгуулах ажлыг 19,200,000 (арван есөн сая хоёр зуун мянга) төгрөгөөр “Өрнөх гүнт” ХХК-тай, Сумдын төвлөрсөн хогийн цэгт ландфиллын аргыг хэрэгжүүлэх жишиг зураг төсөв боловсруулах ажлыг 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр “Нарлаг хөхий” ХХК-тай тус тус гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өрнөх гүнт” ХХК (Ц.Булганчимэг), “Нарлаг хөхий” ХХК (Б.Мөнхбат)-д тус тус үүрэг болгосугай.

3. Дээр дурдсан ажлуудын зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4. Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн

сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

